АНУ-ын цэргийн командлал нисэгчгvй нисдэг аппаратын баазыг Африкийн баруун-хойд хэсэгт байгуулах толовлогоотэй байна. Бvс нутагт «Аль-Каида» болон тvvний хань хамсаатнуудын ажиллагааны тухай тагнуулын мэдээ баримт авах нисэгчгvй нисдэг аппаратуудыг баазад байрлуулна. Тvvнийг Мали улсын зvvн хил орчмын Нигерийн нутаг дэвсгэрт байгуулах бололтой. Одоо энд францын цэрэг лалын зэвсэгт бvлгvvдийн эсрэг ажиллагаанд оролцож байна. Саналыг сайшаавал америкийн 300 орчим цэргийг Нигерт татан шилжvvлэх тухай vvний омно америкийн «Нью-Йорк таймс» сонин мэдээлсэн билээ. Тvvнээс гадна ийм баазыг Буркина Фасод байгуулах хувилбрыг авч vзэж байна. Үvний хамт АНУ цэргийн албан хаагчдаа Хойд Африкт цэргийн ажиллагаанд оролцуулах гээгvйг Торийн департаментын толоологч Виктория Нуланд батлан илэрхийлэв.